

## ЭНЭТХЭГ СУДЛАЛЫН МОНГОЛ ТӨВ БАЙГУУЛАГДАВ

2006 оны 12 дугаар сарын 12-нд Шинжлэх ухааны академийн Олон улс судлалын хүрээлэнгийн дэргэд Энэтхэг судлалын төвийг байгуулах хурал болов. Уг хуралд манай нэртэй эрдэмтэд, судлаачид болон улс орны цөм болсон олон салбарын төлөөлөгчид оролцож, Монгол улсад суугаа БНЭУ-ын элчин сайд Ё.Варма уригдлаа. Анхны хурлаараа Төвийн дүрмийг баталж, Удирдах Зөвлөлийг 25 хүний бүрэлдхүүнтэй сонгов. Төвийн тэргүүнээр доктор О.Нямдавааг, орлогчоор доктор Ч.Дашпүрэв, доктор Л.Хайсаңдай нарыг, хүндэт даргаар академич, доктор, профессор Ш.Бира нарыг тус тус сонголоо.

Төвийн гол зорилго бол Монгол оронтой 2500-3000 жилийн түүхэн харилцаатай явж ирсэн БНЭУ-ын түүх, соёл, урлаг, харилцаа холбоо мэдээллийн технологи, биотехнологийн ололт амжилт болон Энэтхэгийн монголжуу 30 сая хүний амьдрал ахуй, соёл иргэншил, Монголтой ижил төстэй зүйлийн талаар танилцуулж, улмаар хамтын ажиллагааг дэмжин тэтгэхэд зохих тус нэмэр оруулах, хоёр талын хамтын ажиллагаа явуулахыг хүсэгчдэд зөвлөгөө өгөх, Монгол-Энэтхэгийн харилцаа, хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх санал боловсруулах, хоёр орны эрдэмтдийн уулзалтыг зохион байгуулахад оршино.

Уг төвийн бүрэлдхүүнд манай нэрт академич Б.Энхтүвшин, Д.Төмөртоогоо, доктор Г.Аким, Ё.Отгонбаяр, Д.Шүрхүү, Ш.Сопинбаяр, Г.Төмөрчулуун, Г.Энхбаяр, М.Отгон, Д.Гэндэндарам, хамба лам Ч.Дамбажав, Нийслэлийн засаг даргын орлогч Б.Баатарзориг, МОНЦАМЭ агентлагийн дарга Д.Ариунболд, Урчуудын эвлэлийн Хорооны дэд дарга П.Цэгмид, захирал Д.Гантөмөр, Ж.Юра, Д.Ширэндэв, Төр засгийн амралт, үйлчилгээний цогцолборын дарга Б.Нямаа, Эйртранс компаний ерөнхий захирал Т.Чулуунхүү, Пума констракшн компаний ерөнхий захирал Н.Нацагдорж, Монос компаний ерөнхий захирал Л.Хүрэлбаатар, Интерпресс компаний ерөнхий захирал Ж.Энхжаргал нарын зэрэг хүмүүс багтсан байна. Гүйцэтгэх захирлаар доктор Б.Уранчимэгийг томилжээ.

БНЭУ-аас Монгол улсад суугаа Ошц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ё.Варма шинээр байгуулагдаж буй Төвд амжилт хүсээд, бүх талын тусламж дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв. Мөн түүнчлэн эртний уламжлалт харилцаан дээр үндэслэн орчин үеийн ололт амжилтыг монголын залуу үеийнхэнд таниулж, хамтын ажиллагааны шинэ шинэ хэлбэр, салбарыг даяарчлагдан байгаа өнөөгийн ертөнцөд бий болгох шаардлага байгааг онцлон тэмдэглэв. 2006.12.13 Улаанбаатар

*Энэхүү мэдээ 2006 оны 12 дугаар сарын 14 ний өдрийн МОНЦАМЭ болон Улаанбаатар тайме сонины дугаарт тус тус нийтлэгдсэн болно.*

*Б. Уранчимэг*